



ОЛОН УЛСАД МАГАДЛАН ИТГЭМЖЛЭГДСЭН МАНДАХ ИХ СУРГУУЛЬ

NEWSLETTER

Мандах их сургууль болон Капитрон банк хооронд хамтран ажиллах гэрээ байгууллаа


Мандах их сургууль болон Капитрон банк хооронд хамтран ажиллах тухай гэрээ байгуулж, 2023 оны 01-р сарын 05-ны өдөр Мандах их сургуулийн Сургалт эрхэлсэн дэд захирал, Доктор (Ph.D), дэд Профессор Ч. Төрбадрах, Чанарын удирдлага, зохицуулалтын албаны дарга С.Энхтуяа, Капитрон банкны Байгууллагын хөгжил, хүний нөөцийн газрын захирал Ч. Халиун нар гарын үсэг зурлаа.

Хоёр тал хамтын ажиллагааны гэрээнд тусгагдсан үйл ажиллагааны дагуу оюутнуудын дадлагын ажлыг үр дүнтэй зохион байгуулах, суралцагсдыг цагийн болон үндсэн ажлын байраар хангах, шилдэг оюутнуудад зориулсан тусгай төсөл хөтөлбөрийг зарлах, ажилтнуудад боловсролын зэрэг олгох, мэргэжлийн зэрэг ахиулах сургалт дамжаа зохион байгуулах чиглэлээр хамтран ажиллахаар санал солилцлоо.



НББ-ийн сайн дурын ажилтан клубын гишүүд батламжаа гардан авлаа

2022-2023 оны хичээлийн жилийн 1-р улиралд НББ-ийн сайн дурын ажилтан клубын гишүүд 80 цагаар ажлаа төлөвлөж, төлөвлөгөөний дагуу захиалгат ажлыг амжилттай дуусгаж Батламжаа гардан авлаа.



БМИҮЗ Мандах Их Сургуулийн ахиц дэвшлийн тайланд чанарын үнэлгээ хийлээ

БМИҮЗ-өөс байгууллагын магадлан итгэмжлэлийн ахиц дэвшлийн тайланд дүгнэлт гаргах үнэлгээний баг Мандах Их Сургуульд 2023 оны 02 сарын 10-ны өдөр ажиллав. Үнэлгээний багийн ахлагчаар МУИС-ийн Хэрэглээний Шинжлэх Ухааны сургуулийн профессор Г.Анхбаяр /Ph.D./, гишүүнээр СЭЗИС-ийн Салбар дундын судлалын тэнхимийн дэд профессор, /Ph.D./ Ю.Хорлоо, БМИҮЗ-ийн магадлан итгэмжлэл хариуцсан шинжээч Б.Оюунцэцэг /Ph.D./ нар ажиллаж, сургуулийн сургалт, эрдэм шинжилгээ, оюутны үйлчилгээ, сургуулийн орчин, номын сангийн үйл ажиллагаатай танилцаж тус сургуульд ДБМИК-оос өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд үнэлэлт өглөө.



“Нягтлан бодох бүртгэл” бакалаврын хөтөлбөрийн ахиц дэвшилд чанарын үнэлгээ хийж, дүгнэлт гаргах шинжээчийн баг ажиллалаа

2023 оны 2 сарын 15-ны өдөр Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн шинжээч Д.Нямаа /МУИС-ийн Бизнесийн сургуулийн дэд профессор/ Мандах Их сургуульд ирж ажиллав.

Уг ажлын хүрээнд :

- Шинжээч Д.Нямаа /МУИС-ийн Бизнесийн сургуулийн дэд профессор/ - Ахиц дэвшлийн үнэлгээ хийх үйл ажиллагааны талаар танилцуулга хийж, тайланд хамаарах нотлох баримттай танилцаж зарим багш, албан тушаалтнуудтай уулзалт хийж тодруулга авсан.
- Х.Нямбаяр /НББС-ийн захирал дэд профессор/ - НББ бакалаврын сургалтын хөтөлбөрийн ахиц дэвшлийн танилцуулга хийлээ.

Шинжээч Мандах Их сургуулийн удирдлагууд болон ахиц дэвшлийн тайлан бэлтгэх комиссийн гишүүдэд урьдчилсан дүгнэлтийг танилцууллаа.



Нягтлан бодох бүртгэлийн анхан шатны мэдлэг олгох дамжааны төгсөгчид сертификатаа гардан авлаа

2023.01.05 – 2023.02.16 хооронд хичээллэсэн Нягтлан бодох бүртгэлийн анхан шатны мэдлэг олгох дамжааны 13 төгсөгчид сертификат гардан авлаа. Тус дамжаа нь цахим, танхим хосолсон хэлбэрээр болон онлайн хэлбэрээр явагдаж суралцагчдаас хичээлийн багц цагийг бүрэн судлаж хамрагдсан суралцагчдад сертификат өглөө.



МАНДАХ ИХ СУРГУУЛЬ 2022 онд 30 жилийн ой тохиосон Бар жилд болсон онцлох 10 үйл явдал

Мандах их сургууль 2022 онд 30 жилийн ой тохиосон Бар жилд болсон онцлох 10 үйл явдлыг дурдвал:

- Улсын Нягтлан бодох бүртгэлийн XXIII олимпиадад Мандах их сургууль 12 дахь удаагаа тэргүүллээ,
- Мандах Их Сургуулийн үүсгэн байгуулагч Б.Сандагсүрэн агсны нэрэмжит Статистикийн улсын IV олимпиадыг амжилттай зохион байгууллаа
- Инженерийн хөтөлбөрийн анхны диплом хамгаалалт болсон ба инженер эдийн засгийн нээлттэй Улсын олимпиадад амжилттай оролцлоо.
- Швейцарын Холбооны Улсын Эдийн засаг, Технологийн их сургуультай 2016 оноос эхлэн хэрэгжүүлж буй хос диплом олгох хөтөлбөрийн 4 дэх удаагийн төгсөлт боллоо.
- Япон улсын Tohoku их сургуулийн **“EMEX”** оюутан солилцооны хөтөлбөр, Индонезийн Stekom их сургуулиас зохион байгуулсан олон улсын оюутнуудын соёлын солилцооны 2 өдрийн хөтөлбөр болон Ази, Номхон далайн орнуудын “UMAP” хөтөлбөрт оюутнууд амжилттай хамрагдлаа.
- **Олон улсын “Peregrine Global Services”** байгууллагын хөндлөнгийн үнэлгээ болон Боловсролын байгууллагын менежментийн тогтолцоо **ISO21001:2018** стандартын магадлах аудитыг амжилттай хийлгэлээ.
- Номын сан бие даасан 5 давхар шинэ байртай боллоо,
- Сургуулийн захирал Г.Нанжид Монгол Улсын гавьяат багш цол хүртлээ,
- Олон улсын эрдэм шинжилгээний “Мандах-2022” хурал “Дижитал шилжилт ба тогтвортой хөгжил” сэдвийн хүрээнд 5 дахь удаагаа зохион байгууллаа.

30 жилийн ойд зориулан ЭЗБТ "Өрхийн Санхүү" сэдэвт сургалт, Нягтлан бодох бүртгэлийн сургууль Дархан уул аймагт Нягтлан бодох бүртгэлийн мэргэжил дээшлүүлэх сургалт тус тус үнэгүй зохион байгууллаа.



Японы улсын Тохоку их сургуулийн Оюутан солилцооны 2023 оны хаврын семестрийн хөтөлбөрт суралцах оюутныг Мандах их сургуулийн захирал, Профессор Г. Нанжид хүлээн авч уулзлаа

Японы Тохоку их сургуулийн Оюутан солилцооны 2023 оны хаврын семестрийн хөтөлбөрт Мандах их сургуулийн Маркетингийн менежментийн 2-р дамжааны оюутан Б.Баясгалан оролцохоор сонгогдсон.

Солилцооны оюутан ирэх Даваа гаригт Япон улсыг зорих гэж байгаатай холбогдуулан, Мандах их сургуулийн захирал, Проф. Г.Нанжид хүлээн авч уулзлаа. Уулзалтанд Сургалт эрхэлсэн дэд захирал Ч.Төрбадрах, Гадаад харилцаа, хамтын ажиллагааны ажилтан З.Булганаа нар оролцлоо.

Уулзалтаар Оюутан солилцооны 2022 оны намрын семестрийн хөтөлбөрт амжилттай оролцож төгссөн Б. Ичинхорлоо тус хөтөлбөрт хэрхэн оролцсон талаар болон дараагийн солилцооны оюутанд өөрийн туршлага, мэдлэг мэдээллээсээ хуваалцлаа.



“Mandakh university and quality assurance” workshop 2023 амжилттай зохион байгуулагдлаа

Нийт багш ажилчдад Мандах Их Сургуулийн чанарын баталгаажуулалтын тогтолцоо, түүний хэрэгжилт, алба нэгжүүдийн оролцоо, сайжруулалтын талаар нэгдсэн ойлголт өгөх зорилгоор “МАНДАХ ИХ СУРГУУЛЬ БА ЧАНАРЫН БАТАЛГААЖУУЛАЛТ 2023” сургалт 2023 оны 3 дугаар сарын 22-ны өдөр амжилттай зохион байгуулагдлаа.

Тус сургалтанд Мандах Их Сургуулийн нийт 83 багш, ажилчид хамрагдсан ба чанарын баталгаажуулалтын талаар мэдээлэл өгч, харилцан санал солилцлоо.



Green группийн нэрэмжит нээлттэй өдөрлөгийг амжилтай зохион байгууллаа

Үндэсний брэнд бүтээгч Green групп нь Мандах Их Сургуультай хамтын ажиллагааны хүрээнд Хүний нөөцийн нээлттэй өдөрлөг зохион байгууллаа.

Өдөрлөгийн хүрээнд нийт оюутнуудад

Green группийн хэмжээнд байгаа нээлттэй ажлын байрны сонгон шалгаруулалтад нийт 200 оюутан анкет илгээсэн бөгөөд цаашид Green группийн нийт салбарт ажиллах боломж, салбар компаниудад танилцах болон үйлдвэрлэлийн дадлага хийх боломжийг нээв.

Ард Секюрити ХХК-ийн гүйцэтгэх захирал, Apprentice шоуны 1-р улирлын ялагч Ц.Бархастай ярилцан карьер төлөвлөлт болон хувь хүний хөгжлийн талаар хэлэлцүүлэг хийж, 10 оюутанд Green группт ажиллах урилга, 5 оюутанд Green группийн нэрэмжит тэтгэлгийг тус тус олголоо.

Нийт оюутнуудад маань үр өгөөжтэй арга хэмжээ болсонд баяртай байна. Уг үйл ажиллагааг цаашид жил бүр зохион байгуулж ажиллахаар болов.



“Оюутны эрдэм шинжилгээний хурал – 2023” амжилттай Зохион байгуулагдлаа

Оюутнуудын эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг өргөжүүлэх зорилго бүхий Мандах Их сургуулийн оюутны эрдэм шинжилгээний хурал 2023.03.24-нд Номын сангийн 2 давхарын танхимд амжилттай зохион байгуулагдлаа.

Жил бүр уламжлал болгон явагддаг оюутны эрдэм шинжилгээний хуралд тэнхим бүрээс шалгарсан нягтлан бодох бүртгэл, банк санхүү, нийгэм, мэдээллийн технологи болон инженерийн чиглэлийн 18 илтгэл хэлэлцүүлэгдлээ. Энэ удаагийн хурлын шүүгчээр Мандах их сургуулийн эрдэмтэн багш нараас гадна зочин шүүгчээр Капитрон банкны Хамтын ажиллагааны хэлтсийн захирал Б.Батхуяг, Байгууллагын зээлийн хэлтсийн захирал У.Наранбаяр (2011 оны төгсөгч) нар ажиллаж, үнэтэй зөвлөгөө өглөө.

Энэхүү хурал нь оюунлаг, бүтээлч, хандлагаар дүүрэн, судлаач оюутнууд судалгааны арга зүй болон мэдлэг туршлагаа хуваалцсан хурал боллоо.



Инженер технологийн тэнхимээс “Шпагетти гүүр” тэмцээнийг Мандах их сургуулийн I-IV-р түвшний оюутнуудын дунд амжилттай зохион байгууллаа

Уг тэмцээнд 8 ангийн 12 багийн 25 оюутан хамрагдсанаас

I Байр- ИЭЗ-1 түвшний оюутан А.Амармэнд

II Байр НББАХ-4 түвшний оюутан Э.Энх-Амгалан

III Байр ИЭЗ-2 түвшний оюутнууд Б.Шинэхүү, У.Алтан-Очир, Б.Мөнхбаясгалан

Загварлаг гүүрээр ИЭЗ-2 түвшний оюутан Б.Энхжин нар тус тус шалгарлаа.



Уламжлалт “санхүүгийн дунд шатны нягтлан бодох бүртгэлийн мини” олимпиад 2-р түвшний оюутнуудын дунд зохион байгуулагдаж шилдэг 3 оюутан, шилдэг ангийг тодрууллаа

Олимпиад 2023.04.28-ны өдөр Төв байранд зохион байгуулагдлаа. Мини олимпиадад 2-р түвшний 57 оюутан, МИС-Дархан салбарын 2-р курсын 18 оюутан нийт 75 оюутан оролцож шилдэг 3 байр, шилдэг ангийг тодрууллаа. Үүнд

№	Овог	Нэр	Анги	Байр
1	Адарсүрэн	Номиндарь	НББ-Татвар	I
2	Баяртсайхан	Амингоо	Дархан салбар сургууль	II
3	Хоролсүрэн	Цээтогтох	НББ-Эрхзүй	III

Байр	Нийлбэр оноо	Байр
НББ-Татвар	169	I
НББ-Банк	119	II
НББ-Аудит	109.5	III



Нягтлан бодох бүртгэлийн анхан шатны мэдлэг олгох дамжааны төгсөгчид сертификатаа гардан авлаа

Мандах Их сургуулийн зэргийн бус сургалт “Нягтлан бодох бүртгэлийн анхан шатны мэдлэг олгох дамжаа” 2023.03.15 – 2023.04.21 хооронд Цахим, танхим хосолсон хэлбэрээр хичээллэж хичээлийн багц цагийг бүрэн судлаж хамрагдсан 22 суралцагчдад сертификат гардууллаа.



2022-2023 оны Шилдэг оюутан, шилдэг хамт олон, шилдэг клубыг шалгарууллаа

2023.05.09 нд Мандах Их Сургуулийн Үүсгэн байгуулагдсан өдрийг тохилдуулан шилдэг оюутан, шилдэг хамт олон, шилдэг клубийг шалгаруулдаг уламжлалтай билээ. Энэхүү өдөр сурлагаар тэргүүлэгч шилдэг оюутан, эрдэм шинжилгээ судалгааны ажлаар тэргүүлэгч шилдэг оюутнуудыг тус тус шагнав. Мөн тус өдөр сургуулиа төлөөлөн олон улсын уралдаан тэмцээн, олимпиадад амжилттай оролцсон оюутнуудыг шагнаж урамшуулав. Амжилт гаргасан баг хамт олон Үүнд:

- Нягтлан бодох бүртгэлийн 24-р улсын олимпиад багийн төрөлд тэргүүн байр
- Санхүүгийн улсын 9-р олимпиад гутгаар байр
- Мандах Мазаалай сагсан бөмбөгийн эмэгтэй баг – Оюутны лиг II дивизонд тусгай байр
- Инженерчлэлийн эдийн засаг улсын нээлтэй 3-р олимпиадад гутгаар байр
- Грийнвичи олон улсын мэргэжлийн англи хэлний шалгалтад тэнцсэн оюутнуудад сертификат гардуулав.
- Сурлагаар тэргүүлэгч шилдэг оюутан – НББ-Татвар 4-р түвшин оюутан Нямбаяр Уянга
- Эрдэм шинжилгээ судалгааны ажлаар тэргүүлэгч шилдэг оюутан –Банк менежмент 3-р түвшний оюутан П.Мөнхцэцэг
- Нийгэм хүмүүнлэгийн ажлаар тэргүүлэгч шилдэг оюутан – НББ-Статистик 3-р түвшний оюутан Д.Маралмаа
- Шилдэг клуб –K-Club
- 3-р түвшний Шилдэг анги хамт олноор – Санхүү менежмент хөтөлбөр
- 4-р түвшний Шилдэг анги хамт олноор – Нягтлан бодох бүртгэл -Татвар хөтөлбөр



Бакалаврын хөтөлбөрийн төгсөлтийн ёслолын үйл ажиллагаа амжилттай зохион байгуулагдлаа


Мандах Их Сургуулийн бакалаврын хөтөлбөрийн 28 дахь удаагийн төгсөлтийн үйл ажиллагаа 2023 оны 05 сарын 29-ны өдөр амжилттай зохион байгуулагдлаа. Ёслолын үйл ажиллагааг нээж мандах ИС-ийн захирал МУ-ын гавьяат багш профессор Г.Нанжид хөтөлбөрт хамрагдаж амжилттай суралцсан нийт төгсөгчид болон эрдэмтэн багш нар, ажилтнууд, төгсөгчидийн гэр бүлийн төлөөлөлүүдэд баяр хүргэхийн зэрэгцээ цаашдын сурлага хөдөлмөр, ажил амьдралд нь амжилт, сайн сайханы хүслээ. Үйл ажиллагаанд Мандах Их Сургуулийн удирдлага, Эрдмийн зөвлөлийн гишүүд оролцож, төгсөгчдөд амжилт хүсэж, диплом энгэрийн тэмдгийг гардуулж өглөө. Энэ удаагийн төгсөлтөөр Нягтлан бодох бүртгэл, Санхүү, Банк, Логистик менежмент, Программ хангамж, Мэдээлэлийн систем, Механик инженерчлэл хөтөлбөрөөр нийт 180 суралцагч амжилттай төгслөө. Мандах Их Сургууль нь үе үеийн төгсөгчидөөсөө мэргэжлээрээ олон жил ажиллаж бусдыгаа манлайлсан, түүнчлэн сургуулийн үйл ажиллагааг байнга дэмжин хамтран ажилладаг шилдэг төгсөгчдийг шалгаруулдаг уламжлалтай. Сургуулийг дэмжигч шилдэг төгсөгчөөр Мандах ИС-ийг 2002 оны төгсөгч Сити Ойл ХХК-ний захирал Д.Гантулга Мэргэжлээрээ тэргүүлэгч шилдэг төгсөгчөөр Мандах ИС-ийн 1996 оны төгсөгч Сангийн яамны хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ч.Чимидсүрэн нар тодорлоо. Энэ удаагийн төгсөлтөөр Сурлагын амжилтаараа бусдыгаа манлайлсан нийт 12 суралцагч монголын оюутны холбооны “манлайлагч оюутан” медалиар шагнагдсан байна. Амжилттай суралцаж төгссөн буй оюутнууддаа нийт 17 төгсөгчдөд магистрын хөтөлбөрт хөнгөлөлттэй суралцах эрхийн бичгийг гардууллаа. Мөн ажил олгогчын төлөөлөл “Хүлэгтхүннү аудит” ХХК-ийн гүйцэтгэх захирал И.Гүррагчаа ирж 3 төгсөгчид ажлын байрны урилга гардууллаа.

Оюутнуудыг амжилтаас:

- Мандахчууд “Нягтлан бодох бүртгэлийн улсын XXIV олимпиад”-д тэргүүлж, 13 дахь удаагаа алтан медалийн эзэн боллоо. Н.Уянга, П.Маралгоо, Б.Дорждэрэм нар топ 10-д шалгарсан байна.
- Мандах ИС-ийн Дархан салбар сургууль багийн дүнгээр 2-р байр шалгарсан ба хувийн дүнгээр Э.Өлзийбаяр, Л.Ган-Эрдэнэ, Б.Халиун нар топ 10-д шалгарсан байна.
- Мандах ИС-ийн оюутнууд 2 баг Санхүүгийн менежментийн улсын IX олимпиадад амжилттай оролцож, багийн дүнгээр 3-р байрт, багш нарын төрөлд мөн 2-р байрт Төгсөх: Санхүү Менежмент- 4 түвшний оюутан Г.Анхбаяр 1-байранд, Санхүү Менежмент-3 түвшний оюутан Э.Анхзул 4-р байранд, Санхүү Менежмент-3 түвшний оюутан П.Чулуун-Эрдэнэ 5-р байранд тус тус шалгарсан. Дэмжигч байгуулагуудад ажиллах урилгын эздээр Санхүү Менежмент-3 түвшний оюутан Б.Мөнхсүвд, Ө.Энхжаргал, Санхүү Менежмент-4 түвшний оюутан А.Дэлгэрсайхан нар “Шинэлэг сууц” ХХК-д мэргэжлээрээ ажиллах урилгаар тус тус шагнуулав
- Мандах ИС-ийн инженерчлэлийн эдийн засгийн улсын олимпиадад амжилттай оролцож Бизнесийн удирдлага хөтөлбөрийн Б.Солонго 3-р байр, ИЭЗ-ийн 4-р түвшиний оюутан, Санхүү менежментийн хөтөлбөрийн 4-р түвшиний оюутан Х.Цасангуа, Инженер эдийн засгийн 4-р түвшиний оюутан Э.Чүнсрээмятав, Б.Туяацэцэг нар тусгай байранд шалгарсан.
- Инженерийн зураг зүйн олимпиадад амжилттай оролцсон.
- Улсын программчлалын 31-р олимпиадын БҮТЭЭЛИЙН УРАЛДААНД Мандах ИС-ийн МТС-ийн баг "ХҮҮХЭД" апп танин мэдэхүйн бүтээлээр 3-р байр, ПХ-2 курсийн оюутан Б.Сумьяабазар хувийн дүнгээр ТОП-10-т шалгарсан амжилт үзүүлсэн.

Оросын Холбооны Улсаас ирсэн суралцагсад Мандах их сургуулийн Монгол хэлний бэлтгэл ангид амжилттай суралцаж төгслөө

2022-2023 оны хичээлийн жилд Мандах их сургууль гадаадын иргэдэд зориулж, Монгол хэлний нэг жилийн бэлтгэл ангийг нээсэн бөгөөд ОХУ-аас ирсэн 22 суралцагсад энэхүү сургалтанд хамрагдаж, өнөөдөр төгсөлтийн гэрчилгээгээ гардан авлаа. Төгсөгчийн гэрчилгээгээ гардан авсан суралцагсад амжилттай суралцах боломжийг олгосон Мандах их сургуулийн эрдэмтэн багш нар болон ажилтнуудад талархаж буйгаа илэрхийллээ.



“Программ хангамж”-ийн бакалаврын хөтөлбөр магадлан итгэмжлэгдэж гэрчилгээгээ хүлээн авлаа

Мандах ИС-ийн Мэдээлэл, Технологийн сургуулийн “Программ хангамж”-ийн бакалаврын хөтөлбөр Боловсролын Магадлан Итгэмжлэлийн Үндэсний зөвлөлийн Удирдах зөвлөлийн 2023 оны 5 сарын 24-ны өдрийн 24 тоот тогтоолоор 5 жилийн хугацаатай магадлан итгэмжлэгдэж гэрчилгээгээ хүлээн авлаа.

МАГАДЛАН ИТГЭМЖЛЭЛ гэдэг нь чанарын урьдчилан тогтоосон шалгуур, үзүүлэлтүүдийг хангаж байгаа буюу давуулан биелүүлж буй үйл ажиллагааг эрх бүхий хөндлөнгийн этгээд магадлан шалгаж, хүлээн зөвшөөрөх үйл ажиллагаа юм.



Мандах Их Сургуулийн бакалаврын эчнээ хөтөлбөрийн 28 дахь удаагийн төгсөлтийн үйл ажиллагаа 2023 оны 06 сарын 26-ны өдөр амжилттай зохион байгуулагдлаа.

Ёслолын үйл ажиллагааг нээж мандах ИС-ийн захирал МУ-ын гавьяат багш профессор Г.Нанжид хөтөлбөрт хамрагдаж амжилттай суралцсан нийт төгсөгчид болон эрдэмтэн багш нар, ажилтнууд, төгсөгчидийн гэр бүлийн төлөөлөлүүдэд баяр хүргэхийн зэрэгцээ цаашдын сурлага хөдөлмөр, ажил амьдралд нь амжилт, сайн сайханы хүслээ.

Үйл ажиллагаанд Мандах Их Сургуулийн удирдлага, Эрдмийн зөвлөлийн гишүүд оролцож, төгсөгчдөд амжилт хүсэж, диплом энгэрийн тэмдгийг гардуулж өглөө.

Энэ удаагийн төгсөлтөөр нягтлан бодох бүртгэлийн бакалаврын эчнээ хөтөлбөрөөр нийт 163 төгсөгч диплом энгэрийн тэмдэгээ гардан авлаа.

Төгсөлтийн ёслолын үйл ажиллагааны үеэр 3.55-аас дээш голч дүнтэй суралцсан нийт 41 төгсөгчдөд тус сургуулийн магистрын хөтөлбөрт эхний улирлын сургалтын төлбөрийн 40%-ийн хөнгөлөлттэй суралцах эрхийн бичиг олгосон.



Гадаад хамтын ажиллагаа

Мандах их сургууль, БНСУ-ын Чонжу хотын их сургуультай хамтран ажиллахаар боллоо

БНСУ-ын Чонжу хотын их сургуулийн төлөөлөгчид Мандах их сургуулийн удирдлагуудтай 2023 оны 3 дугаар сарын 17-ний өдөр уулзлаа. Уулзалтаар хоёр талын хамтын ажиллагааг хөгжүүлэх чиглэлээр харилцан саналаа солилцов. БНСУ-ын Чонжу их сургууль нь Чанчон мужийн нийслэл Чонжу хотод байрладаг бөгөөд 1947 онд байгуулагдсан, бакалаврын түвшний 8 бүрэлдэхүүн сургууль, ахисан түвшний 5 бүрэлдэхүүн сургуультай, томоохон их сургууль юм. Тус их сургуульд гадаадын 800 гаруй оюутнууд суралцдаг ба БНХАУ, Вьетнам, Монгол улсаас ирсэн оюутнууд ихэнх хувийг эзэлдэг байна.

Уулзалтын эхэнд Чонжу их сургуулийн Гадаад харилцаа, хамтын ажиллагааны газрын профессор Тае Жонг Мандах их сургуульд зочлон ирсэндээ талархаж буйгаа илэрхийлээд, манай сургуультай нягтлан бодох бүртгэл, бизнесийн удирдлага, эдийн засаг, банк санхүүгийн хөтөлбөрөөр 2+2 хөтөлбөрийг хамтран хэрэгжүүлэх боломжтой талаар дурдлаа. Мандах их сургуулийн захирал Г.Нанжид сургуулийнхаа талаар товч танилцуулахдаа Мандах их сургууль гадаадын 20 гаруй их дээд сургуультай багш, оюутан солилцоо, эрдэм шинжилгээ, судалгааны чиглэлээр хамтран ажиллаж, туршлагаа хуваалцдаг талаар дурдаад, хоёр талын хамтын ажиллагааг дараах 3 хэлбэрээр хөгжүүлэх боломжтой талаар санал хэлэлцүүлэв. Үүнд:

1. Хос диплом олгох 2+2 хөтөлбөр
2. Оюутан солилцооны хөтөлбөр /3-6 сар/
3. Мандах их сургуулийн оюутнууд Чонжу их сургуульд шилжин суралцах хөтөлбөр

Талууд Оюутан солилцооны хөтөлбөрөөр дамжуулан хоёр орны соёлын солилцооны хөтөлбөрийг хэрэгжүүлэх, багш, ажилтнуудаа харилцан солилцож, туршлагаа хуваалцах, эрдэм шинжилгээ, судалгааны чиглэлээр хамтын ажиллагаагаа өргөн хүрээнд хөгжүүлэх талаар санал нэгдэв.

Уулзалтын төгсгөлд хоёр тал зохих бэлтгэл ажлыг хангаад, ирэх 5 дугаар сард Хамтын ажиллагааны гэрээнд гарын үсэг зурж, баталгаажуулахаар харилцан тохиролцлоо.



Гадаад хамтын ажиллагаа

Мандах их сургуулийн төлөөлөгчид Дэлхийн Боловсролын Түншлэгч нарын 12 дахь удаагийн хуралд оролцлоо

2023 оны 04 сарын 24-29 өдрүүдэд БНХАУ-д зохион байгуулагдсан “THE 12TH EDUCATIONAL GLOBAL PARTNERS CONFERENCE”-арга хэмжээнд Сургалт эрхэлсэн дэд захирал Ч.Төрбадрах, НББ-ийн сургуулийн захирал Х.Нямбаяр нар оролцов.

Тус арга хэмжээ нь БНХАУ-ын их, дээд сургуулиуд, олон улсын болон Монгол улсын ЕБС, их дээд сургуулиудын хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилготой юм.

Хурлын арга хэмжээний үеэр оролцогчид салбар хуралдаан болон түншлэгч нарын уулзалтад оролцож, БНХАУ-ын их дээд сургуулиудтай харилцаа, холбоо тогтоож, 3 их сургуулийн сургалтын орчинтой танилцав.

Мандах их сургуулийн төлөөлөгчид “Shanghai Lixin University of Accounting and Finance” сургуульд зочилж, хоёр талын уулзалт зохион байгуулж, хамтран ажиллахаар тохиролцлоо. Уулзалтанд тус их сургуулийн дэд захирал Чен Жи, Гадаад хамтын ажиллагааны газрын дэд дарга Яо Жи нар оролцлоо.



Гадаад хамтын ажиллагаа

Мандах их сургууль болон БНСУ-ын Чонжу их сургуулийн хооронд Хамтын ажиллагааны санамж бичиг байгууллаа

БНСУ-ын Чонжу их сургуулийн төлөөлөгчид 2023 оны 6-р сарын 15-ны өдөр Мандах их сургуульд айлчиллаа. Төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд Чонжу их сургуулийн ерөнхийлөгч Чон Су Ча, Гадаад хамтын ажиллагааны газрын захирал Хюк Жаи Квон, Гадаад хамтын ажиллагааны газрын ажилтан Жонмин Ли нар байлаа. Айлчлалын үеэр Хамтын ажиллагааны санамж бичигт гарын үсэг зурах ёслолын ажиллагаа боллоо. Ёслолын ажиллагаанд Мандах их сургуулийн захирал Г. Нанжид, Сургалт эрхэлсэн дэд захирал Ч. Төрбадрах, Гадаад харилцаа, хамтын ажиллагааны ажилтан З. Булганаа нар оролцов.

Энэ оны 3-р сард Мандах их сургууль дээр болсон уулзалтын үеэр хоёр тал хамтран ажиллах чиглэлийн талаар харилцан санал солилцож, улмаар бэлтгэл ажлыг ханган, өнөөдөр Санамж бичигт гарын үсэг зурж, баталгаажууллаа.

Санамж бичгийн хүрээнд багш, ажилтан, оюутны богино хугацааны танилцах айлчлалыг зохион байгуулах, эрдэмтэн багш, оюутнуудыг сургалт, семинар, лекц, эрдэм шинжилгээний хуралд оролцуулах, хамтарсан эрдэм шинжилгээний ажлыг зохион байгуулах, хос диплом олгох хөтөлбөр болон 3+1, 2+2 хамтарсан хөтөлбөр хэрэгжүүлэх чиглэлээр хамтран ажиллах юм.



Дотоод хамтын ажиллагаа

Мандах их сургууль болон Худалдаа Хөгжлийн Банкны хооронд хамтран ажиллах гэрээ байгууллаа

Мандах их сургууль болон Худалдаа Хөгжлийн Банкны хооронд хамтран ажиллах тухай гэрээ байгуулж, 2023 оны 3-р сарын 23-ны өдөр гарын үсэг зурж баталгаажууллаа.

Хоёр тал Хамтын ажиллагааны гэрээнд тусгагдсан үйл ажиллагааны дагуу оюутнуудын дадлагын ажлыг үр дүнтэй зохион байгуулах, суралцагсдыг цагийн болон үндсэн ажлын байраар хангах, шилдэг оюутнуудад зориулсан тусгай төсөл хөтөлбөрийг зохион байгуулах, ажилтнуудад боловсролын зэрэг олгох, зэрэг ахиулах, сургалт, эрдэм шинжилгээ судалгааны чиглэлээр хамтран ажиллахаар санал солилцлоо.



Санхүүгийн менежментийн улсын IX олимпиадад амжилттай оролцов

2023 оны 04 сарын 13-аас 04 сарын 21-ны хооронд Санхүү Эдийн Засгийн Их Сургууль болон Их Засаг ОУИС-аас зохион байгуулсан. Санхүүгийн Менежментийн Улсын IX олимпиадад Мандах Их Сургууль хувийн дүнгээр 1,4,5-р байр, багийн дүнгээр 2-р байр, багш нарийн төрлөөр 2-р байруудад тус тус шалгарав.

Тус олимпиад нь 2 үе шаттайгаар зохион байгуулагддаг ба чадварлаг боловсон хүчнийг зах зээлд нийлүүлэхэд бодитой түлхэц болж санхүүгийн чиглэлээр сурч буй оюутнуудын дунд улсын хэмжээнд санхүүгийн чиглэлээр мэргэжилтэн бэлтгэдэг 10 гаруй их, дээд сургуулиудын оюутнууд оролцдог өргөн хүрээний олимпиад юм.

Хувийн дүнгээр:

- 1-байранд Санхүү Менежмент- 4 түвшний оюутан Г.Анхбаяр,
- 4-р байранд Санхүү Менежмент-3 түвшний оюутан Э.Анхзул,
- 5-р байранд Санхүү Менежмент-3 түвшний оюутан П.Чулуун-Эрдэнэ тус тус шалгарав.

Багийн дүнгээр:

- Мандах Их Сургуулийн “Blades” баг 3-р байр
- Мандах Их Сургуулийн “Shark” баг 5-р байр

Багш нарын төрлөөр:

- С.Цолмон, Г.Лхамдулам багш нар 2-р байр
- Дэмжигч байгууллагуудад ажиллах урилгын эздээр

- Санхүү Менежмент-3 түвшний оюутан Б.Мөнхсүвд, Ө.Энхжаргал, Санхүү Менежмент-4 түвшний оюутан А.Дэлгэрсайхан нар “Шинэлэг сууц” ХХК-д мэргэжлээрээ ажиллах урилгаар тус тус шагнуулав



НББ-татвар 3 дамжааны оюутан 3.Түшигмаа оюутны эрдэм шинжилгээний хуралд 3-р байрт шалгарлаа

Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чадварыг бэхжүүлэх, соён гэгээрүүлэх зорилготой Монголбанкны дэргэдэх Санхүүгийн мэдээллийн албаны нэрэмжит “Эрдэм шинжилгээний бага хурал” 2023 оны 5 дугаар сарын 17-ны өдөр Монгол банкны “Г” байрны хурлын танхимд болж өндөрлөлөө. Энэ удаагийн хурлын 2 дах шатанд 14 эрдэм шинжилгээний илтгэл шалгарч хэлэлцэгдснээс Мандах Их сургууль НББ-Татвар 3-р дамжааны оюутан **3.ТҮШИГМАА**-ийн **“Цахим луйвар, залилангийн гэмт хэргийг бууруулах оновчтой арга замыг үнэлэх нь”** сэдэвт илтгэл (удирдагч багш БШТ-ийн дэд профессор, PhD. А.Наранцэцэг, багш Г.Энх-Отгон) **III** байрт шалгарч өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнагдлаа.

Тус хуралд МУИС, ШУИС, ДХИС, СЭЗИС, Шихихутаг их сургуулийн оюутнуудын илтгэл оролцож, СЭЗИС-ийн Б.Соёлмаа, Б.Даваадэмбэрэл “Мөнгө угаах гэмт гэмт хэрэг татвараас зайлсхийх болон үндэслэлгүй хөрөнгөжих асуудлын нөлөөг судлах нь” илтгэл I байр, СЭЗИС-ийн Б.Мөрөн, Б.Билгүүн, Б.Тэмүүлэн “Виртуал хөрөнгийн салбарын эдийн засагт үзүүлэх нөлөө (Монгол Улсын жишээн дээр)” илтгэл II байр эзлэв.



Санхүүгийн менежментийн улсын IX олимпиадад амжилттай оролцов

2023 оны 04 сарын 13-аас 04 сарын 21-ны хооронд Санхүү Эдийн Засгийн Их Сургууль болон Их Засаг ОУИС-аас зохион байгуулсан. Санхүүгийн Менежментийн Улсын IX олимпиадад Мандах Их Сургууль хувийн дүнгээр 1,4,5-р байр, багийн дүнгээр 2-р байр, багш нарийн төрлөөр 2-р байруудад тус тус шалгарав.

Тус олимпиад нь 2 үе шаттайгаар зохион байгуулагддаг ба чадварлаг боловсон хүчнийг зах зээлд нийлүүлэхэд бодитой түлхэц болж санхүүгийн чиглэлээр сурч буй оюутнуудын дунд улсын хэмжээнд санхүүгийн чиглэлээр мэргэжилтэн бэлтгэдэг 10 гаруй их, дээд сургуулиудын оюутнууд оролцдог өргөн хүрээний олимпиад юм.

Хувийн дүнгээр:

- 1-байранд Санхүү Менежмент- 4 түвшний оюутан Г.Анхбаяр,
- 4-р байранд Санхүү Менежмент-3 түвшний оюутан Э.Анхзул,
- 5-р байранд Санхүү Менежмент-3 түвшний оюутан П.Чулуун-Эрдэнэ тус тус шалгарав.

Багийн дүнгээр:

- Мандах Их Сургуулийн “Blades” баг 3-р байр
- Мандах Их Сургуулийн “Shark” баг 5-р байр

Багш нарын төрлөөр:

- С.Цолмон, Г.Лхамдулам багш нар 2-р байр
- Дэмжигч байгууллагуудад ажиллах урилгын эздээр

- Санхүү Менежмент-3 түвшний оюутан Б.Мөнхсүвд, Ө.Энхжаргал, Санхүү Менежмент-4 түвшний оюутан А.Дэлгэрсайхан нар “Шинэлэг сууц” ХХК-д мэргэжлээрээ ажиллах урилгаар тус тус шагнуулав



Тэмцээн уралдаан

Ахисан түвшний сургууль, Нягтлан бодох бүртгэлийн сургуулийн нэрэмжит Магистр болон эчнээ хөтөлбөрийн суралцагчдын дундах спортын 4 төрөлт тэмцээн амжилттай боллоо

Мандах их сургуулийн АТС, НББС-ийн нэрэмжит магистр болон эчнээ хөтөлбөрийн уламжлалт спортын тэмцээн 2023 оны 03 сарын 05-ны өдөр амжилттай зохион байгуулагдаж өндөрлөлөө.

Энэхүү тэмцээнд нийт 12 баг тамирчид сагсан бөмбөг, гар бөмбөг, ширээний теннис, дартс гэсэн 4 төрлөөр өрсөлдөж тамирчдын хурд хүрч авхаалж самбааг сорин өрсөлдлөө.



Редакцийн зөвлөл:

Ч.Төрбадрах / Сургалт эрхэлсэн проректор /
И-мэйл: turbadrakh@mandakh.edu.mn

З.Булганаа / Гадаад харилцаа, хамтын ажиллагаа хариуцсан ажилтан /
И-мэйл: foreignrelations@mandakh.edu.mn

Г.Энхжин / Сургалтын алба /
И-мэйл: Enkhjin@mandakh.edu.mn

Ажлын байрны нээлттэй өдөрлөг-2021 зохион байгуулагдлаа

Мандах Их Сургуулийн Оюутны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төв, Маркетингийн комисстой хамтран төгсөгч болон 3,4-р курсын оюутнуудыг дадлагын болон байнгын ажлын байранд зуучлах, хамтран ажиллагч байгууллагуудын хүний нөөцийг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор “Ажлын байрны нээлттэй өдөрлөг”-ийг жил бүрийн 12 сард зохион байгуулдаг. Энэ хичээлийн жилийн “Ажлын байрны нээлттэй өдөрлөг”-ийн арга хэмжээ 2021 оны 12 сарын 7,8-ны өдрүүдэд боллоо.



Өдөрлөгийн үеэр ажил олгогчдийн төлөөлөлтэй уулзаж, оюутан болон төгсөгчдийн мэдлэг, чадвар, хандлагын талаар нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулсан нь бидний цаашдын үйл ажиллагаа, сургалтын хөтөлбөрийг сайжруулахад ач холбогдол өгсөн уулзалт боллоо.



Редакцийн зөвлөл:

Ч.Төрбадрах / Сургалтын эрхэлсэн дэд захирал /
И-мэйл: turbadrakh@mandakh.edu.mn

З.Булганаа / Гадаад харилцаа, хамтын ажиллагаа хариуцсан ажилтан /
И-мэйл: foreignrelations@mandakh.edu.mn

Г.Энхжин/ Номын санч /
И-мэйл: Enkhjin@mandakh.edu.mn